



Улсын цагаачлалын албанаас гаргасан шийдвэрийн эсрэг хэрхэн гомдол гаргах вэ?

Та Улсын цагаачлалын албанаас (Bundesamtes für Migration / BFM) татгалзсан хариу авсан бол?

Хэрвээ та үүний эсрэг гомдол гаргах буюу зөвлөлгөө авахийг хүсвэл нэн даруй хууль зүйн зөвлөлгөө өгөх газар болон хуульч, өмгөөлөгчид хандах хэрэгтэй. Цаг хугацаа алдалгүй хурдан хөөцөлдөх хэрэгтэй, учир нь гомдол гаргах хугацааны дотор таныг албадан саатуулж болзошгүйг анхаарах хэрэгтэй. Хэрвээ та хуулийн зөвлөлгөө авах боломжгүй бөгөөд даруй гомдол гаргахыг хүсэж байгаа бол энэ заавар танд туслах болно. Энэ нь Швейцар улсад орогнол эрэгчид туслах төрийн бус байгууллагаас орогнол эрэгчид болон цагаачлахыг хүсэгчдийн эрхийг хамгаалахад зориулан гаргасан заавар юм.

Үүнийг маш хичээнгүйлэн уншиж өгөгдсөн заалтуудын дагуу ажиллаарай.

1. Та үүнийг зайлшгүй мэдэх ёстой

→ **Гомдолыг зөвхөн нэг удаа гаргана.**

Хариуцсан газар нь цагаачлалтай холбогдсон асуудлаар эцсийн шийдвэр гаргах эрх бүхий дээд шатны байгууллага Улсын засаг захиргааны шүүх (Bundesverwaltungsgericht) болно.

Хаяг:

Bundesverwaltungsgericht (<http://www.bundesverwaltungsgericht.ch/>)

Postfach, CH-3000 Bern 14

Утас: +41 (0)58 705 26 26, факс: +41 (0)58 705 29 80

→ **Заасан хугацаанаас хэтрэхгүй**

Таны авсан шийдвэр бичгийн төгсгөлд буй «Эрх зүйн талын мэдээлэл» гэсэн хэсэгт байгаа гомдолыг хэдий хугацаанд багтаж гаргах талаар мэдээлэлийг анхаар. Шийдвэр бичгийн төрлөөс хамаарч хугацаа өөр өөр байна. Үүнд дараах 2 төрөл:

1. Таны орогнох хүсэлтийг **татгалзсан шийдвэр**. Энэ тохиолдолд та шийдвэр авснаас хойш **30 хоногт** багтаж гомдол гаргах ёстой. Үүнд хагас, бүтэн сайн болон баярын өдрүүд тооцогдоно.
2. Таны орогнох хүсэлтийг **хүлээж аваагүй шийдвэр**, таны хүсэлтийг үндэслэлгүй, хууран мэхэлсэн, итгэл үнэмшилгүй гэж үзсэн. Энэ тохиолдолд та шийдвэр авснаас хойш ажлын **таван өдөрт** багтаж гомдол гаргах ёстой. Үүнд хагас, бүтэн сайн болон баярын өдрүүд тооцогдохгүй. **Анхаар: Европын аль нэг орон руу буцаах шийдвэр гарсан тохиолдолд гомдолын өргөдөл хугацаа сунгахад нөлөөлөхгүй!**

Хугацаа алдахгүйн тулд та гомдолоо эхлээд факсаар явуулаад араас нь оригиналыг шуудангаар явуулбал тохиромжтой.

2. Баримт материалуудыг захиалах

Гомдолоо нотолгоожуулахын тулд цагаачлалын албанаас тухайн шийдвэр гаргахад үндэслэл болсон материалуудыг өөртөө авсан байвал танд гомдол гаргахад хялбар болно. Хэрвээ танд эдгээр нь автоматаар өгөгдөөгүй тохиолдолд та маш хурдан Улсын цагаачлалын албанд өөрийн орогнох хүсэлттэй холбогдсон материалуудыг үзэх хүсэлт гаргах хэрэгтэй.

Үүнд та **материал үзэх хүсэлтийн А** хуудсыг (Akteneinsichtsgesuch) ашиглана. Тухайн хуудас дээр ✍ ийм тэмдэг байгаа газар бүрийг бөглөнө.

→ **Доорх дарааллын дагуу нэгбүрчлэн бөглөж явуулна:**

- 1 Улсын цагаачлалын албаны шийдвэрт дурьдагдсан бүх хүний овог нэр, төрсөн он сар өдөр, тухайн амьдарч буй хаяг

- 2 Газар, он сар өдөр

- 3 N-дугаар (Цагаачлалын албаны шийдвэрийн зүүн дээд хэсэгт байгаа зургаан оронтой тоо)

- 4 Цагаачлалын албаны шийдвэр гарсан он сар өдөр (Мөн тухайн шийдвэрийн зүүн дээд хэсэгт байгаа)

- 5 Материал үзэх хүсэлтийн хуудас дээр гарын үсэг зурна.

- 6 Хуудсыг баталгаажуулсан захидлаар дараах хаяг руу явуулна: Bundesamt für Migration, Quellenweg 6, 3003 Bern-Wabern.

Танд цөөн хоногийн дараа асуулгын протокол болон бусад материалуудын хуулбарыг ирүүлнэ. Та үүнд төлбөр төлөх ёсгүй.

3. Гомдол гаргахад бэлтгэх

→ **Та нийгмийн халамжын тэтгэлэг авдаг уу?**

Хэрвээ авдаг бол тухайн **нийгмийн халамжын газраас үүнийг баталсан тодорхойлолт** гаргуулж өргөдөлдөө хавсаргана. Хэрвээ та энэ тодорхойлолтыг гомдлын хугацаа өнгөрсөн хойно авсан бол даруй араас нь боломжын хэрээр хурдан явуулах хэрэгтэй.

→ **Улсын цагаачлалын албаны шийдвэрийг орчуулуулна.**

Цагаачлалын албаны шийдвэрт дурьдсан таны орогнол хүссэн хүсэлтийг татгалзсан үндэслэлүүдтэй танилцаж энэ талаар үүрийн санал бодлоо гомдлын өргөдөл бичигтээ тусгана

→ **Нотолгоо, баримт бүрдүүлнэ.**

Хэрэг болж магадгүй гэсэн бөгөөд өмнө нь Швейцар улсын албан байгууллагуудад өгч байгаагүй **нотолгоо, баримт материалуудыг** (эмчийн тодорхойлолт, баривчлах тушаал, шүүхийн тогтоол г.м) гомдлын бичигтээ хавсаргана. Эдгээр материалыг цаг алдалгүй зохих хугацаанд амжиж бүрдүүлэх хэрэгтэй.

4. Гомдлын өргөдөл бичих

Гомдлын өргөдөл герман, франц, итали хэлний аль нэг дээр бичигдсэн байх хэрэгтэй. Магадгүй та өргөдөл бичихэд туслачихаар хэн нэгнийг таньдаг бол туслуулж болно, эсвэл та гомдлын өгөгдсөн бэлэн загвар **В хуудсыг** ашиглаж болно. Үүн дээр байх чухал зүйлсийн нэлээд нь бэлэн хэвлэгдсэн байгаа бөгөөд **та зөвхөн өөрийн хувийн байдалд хамаарах зүйлсийг нэмэж оруулж бөглөөд** бэлэн болно. Тухайн хуудас дээр ✍ ийм тэмдэг байгаа газар бүрийг бөглөнө. Бичих зүйлс чинь багтахгүй бол нэмэлт цаасан дээр бичээд хавсаргана.

→ **В-хуудсыг доорх дарааллын дагуу нэгбүрчлэн бөглөж явуулна:**

- 7 Газар, он сар өдөр

- 8 Улсын цагаачлалын албаны шийдвэрт дурьдагдсан бүх хүний овог нэр, төрсөн он сар өдөр, тухайн амьдарч буй хаяг

- 9 Цагаачлалын албаны шийдвэр гарсан он сар өдөр (Мөн тухайн шийдвэрийн зүүн дээд хэсэгт байгаа)

- 10 N-дугаар (Цагаачлалын албаны шийдвэрийн зүүн дээд хэсэгт байгаа зургаан оронтой тоо)

11 Энэ хэсэг таны гомдлын хамгийн чухал хэсэг. Үүнд та цагаачлалын албанаас гаргасан шийдвэрийг яагаад хүлээн зөвшөөрөхгүй гэж үзэж байгаа болон ямар учраас та Швейцар улсад үлдэхийг хүсэж байгаа үндэслэлээ маш тодорхой тайлбарлаж бичнэ. Өгөгдсөн зайнд бичих зүйлс чинь багтахгүй бол нэмэлт цаасан дээр бичиж хавсаргана. Анхаарах зүйлс:

- Цагаачлалын албаны шийдвэрт дурьдагдсан татгалзсан үндэслэл бүрийг авч үзэх хэрэгтэй.
- Тухайн шийдвэрт таны орогнол хүссэн үндэслэлийг итгэл, үнэмшилгүй гэж үзсэн бол та үүний эсрэг өөрийн зүгээс өгч болох бүх тайлбарыг өгч, энэ үл ойлголцолын байдлыг тодруулахыг хичээх хэрэгтэй.
- Та эх орон руугаа буцсан тохиолдолд таныг ямар нөхцөл байдал хүлээж байна вэ? Таныг хэн хэзээ юуны улмаас мөрдөж мөшгөж, хяхаж хавчиж буй талаар дэлгэрэнгүй тайлбарлаж бичнэ.
- Хэрвээ та мөрдөж мөшгөгдөж буйгаа нотолгоожуулж чадвал бүр сайн. Өмнө нь өгөөгүй бүх нотолгоо баримтыг (эмчийн тодорхойлолт, баривчлах тушаал, шүүхийн тогтоол г.м) өргөдөлдөө хавсаргаж ямар учраас энд хамааралтайг тайлбарлана.

Үүнээс гадна гомдол гаргах 5 ажлын өдрийн хугацаатай тохиолдолд анхаарах зүйлс:

- Хэрвээ та биеийн байцаалтын бичиг баримт, гадаад паспортаа өгөөгүй бол яг ямар шалтгаанаас гэдгийг тайлбарлана.
- Хэрвээ цагаачлалын албанаас өөрийн байдалтай холбогдсон тодруулалт хийлгэх шаардлагатай гэж үзвэл үүнийг тодорхой гаргаж бичнэ. (Жишээ нь, ямар нэгэн тодорхой үйл явдал, улс төрийн байдалтай холбогдсон г.м)
- Хэрвээ цагаачлалын албанаас таныг өмнө нь байсан гуравдагч орон руу гаргах шийдвэр гаргасан бол та яагаад тэр орон руу эргэн очиж болохгүйг үндэслэнэ. (Жишээ нь, тэр орон намайг шууд нутаг руу маань буцааж болзошгүй гэж айж байна эсвэл Швейцарт миний хамаатан, ойр дотны хүмүүсээс амьдардаг г.м)

Европын холбооны аль нэг орон юмуу Норвеги, Исланд руу буцаан шилжүүлэх шийдвэр гарсан тохиолдолд гомдлын өргөдөл хугацаа сунгахад нөлөөлөхгүй:

Энэ нь та хэдийвээр гомдол гаргасан ч гэсэн Швейцар улсыг орхин гарах шийдвэр гарна гэсэн үг. Ийм шийдвэр ихэвчлэн таны өмнө нь байсан Европын орон таныг буцааж авахыг зөвшөөрсөн тохиолдолд гарна. Энэ тохиолдолд та тэр орон таны орогнол хайж дүрвэх болсон шалтгааныг ямар үндэслэлээр шалгахыг татгалзсан болон нутагтаа буцсан тохиолдолд ямар ямар аюул нүүрлэж болох талаар (хүний эрхийн эсрэг, хяхаж хавчсан) тодорхой гаргаж бичээд гомдлын дагуу «хугацаа сунгаж» өгөхийг шаардсан хүсэлтээ бичнэ.

12 Та орогнол эрэгчийн хувьд хүлээн зөвшөөрөгдөөгүй тохиолдолд Швейцар улсад **түр хугацаагаар** үлдэх (**F-зөвшөөрөл**) боломжтой, хэрвээ таныг **буцаан гаргах боломжгүй** тохиолдолд. Үүнд гуравдагч орон хүний эрхийг үл харгалзан таныг эх орон руу чинь буцаах магадлалтай тохиолдолд тэр орон руу шилжүүлэх боломжгүй гэж үзнэ. Жишээ нь таньд эх орондоо эргэж очиход энд дурьдагдсанаас өөр ямар нэг шалтгааны улмаас **аюул нүүрлэх** г.м;

Энд та эх орон руу буцаахын эсрэг дээр дурьдагдсанаас өөр шалтгаан байгаа бол тэр бүгдийг тодорхой гаргаж бичнэ. Жишээ нь дараахь нөхцөлүүд байж болно:

- **Эрүүл мэндийн тодорхой шалтгааны** улмаас Швейцар улсыг орхин гарах боломжгүй, ямар нэгэн хүнд өвчнөөр өвдсөн бөгөөд тэр нь зөвхөн Швейцарт эмчлэгдэх боломжтой. Энэ тохиолдолд та тухайн өвчний оношийн талаар (хугацааны хувьд шинэхэн) эмчийн тодорхойлолт өргөдөлдөө хавсаргаад, эмчлүүлээгүй тохиолдолд ямар хор уршигтай болохыг тайлбарлаж бичнэ. Мөн Улсын засаг захиргааны шүүхээс (Bundesverwaltungsgericht) энэ талаар шалгаж өгнө үү гэсэн хүсэлт гаргах хэрэгтэй.

Цагаачлалын хуулийн
(http://www.admin.ch/ch/d/sr/c142_31.html)

дагуу Швейцар улсад орогнол эрэгчидэд цагаачлалын эрх олгох:

Цагаачлалын хуулийн 3 дугаар зүйл

«Дүрвэгч гэдэг нь эх орондоо эсвэл хамгийн сүүлд амьдарч байсан оронд арьс өнгө, шашин шүтлэг, улсын харяат байдал, нийгмийн ямар нэг бүлэгт хамааралтай байдалаараа эсвэл улс төрийн үзэл бодолоосоо болж ноцтой ад үзэгдэж байгаа эсвэл ийм дорд байдалд орж болзошгүй гэсэн үндэслэлтэй айдастай хүнийг хэлнэ. Ноцтой дорд байдалын тоонд түүний бие бялдар, амь нас, эрх чөлөөг аюултай байдал болон тэсэхийн аргагүй сэтгэл санааны дарамтанд оруулж буй арга хэмжээнүүд багтана. Эмэгтэйчүүдийн тусгай дүрвэх шалтгааныг харгалзаж үзэх ёстой.»

- Хэрвээ эх оронд тань **ерөнхий** (улс төрийн) **хүчирхийлэл, иргэний дайны** байдал ноёрхож байгаа бол таныг эргэж очсон тохиолдолд ямар аюул нүүрлэж болох вэ гэдгийг тайлбарлаж бичнэ
- Цагаачлалын алба(BFM) шийдвэрт та **өөрийн орон дотроо хамгаалалт хайх боломжтой** гэсэн үндэслэл элбэг дурьдагдана. Таныг эх орондоо, дотооддоо өөрийн чинь хувьд аюул багатай газарт шилжин суурьшиж болох боломжтой гэж үзэж байгаа юм. Гэтэл ийм шилжин суурьшилт нь таны хувьд боломжгүй байж болно. Энэ тохиолдолд дараахь үндэслэлүүд тус болох магадлалтай:
 - *Эдийн засгийн байдлаас хамаарч* өөр газарт шилжин суурьших боломжгүй, (Жишээ нь, хэлний мэдлэг, боловсролын байдлаас юмуу тухайн үеийн нөхцөл байдал г.м шалтгаанаас үүдээд ажлын байр олдохгүй)
 - *Шилжин суурьших боломжтой газар таньд байхгүй.* (Жишээ нь, өөр нутагт танил тал, хамаатан садан байхгүй, урт богино хугацаагаар тэнд огт амьдарч байгаагүй, тэндхийн хэлийг мэдэхгүй г.м)
 - Эсвэл та гэр бүлийн байдал (гэр бүл маш олуул) болон нас, хүйсний байдлаас хамаараад өөр газарт шилжин суурьших боломжгүй.

13 Гомдлын сүүлийн хуудсан дээр та өргөдөлдөө хавсаргаж явуулах бүх нотолгоо, баримт материалуудыг жагсааж бичнэ. Нотолгоо болох баримт материалуудыг өөртөө хувилаж авч үлдээд эхийг (оригиналыг) явуулна. Үүнээс гадна орогнол хүсэлтийн дагуу Цагаачлалын албанаас (BFM)-с авсан шийдвэрийн хувилбарыг хавсаргана. Хэрвээ та нийгмийн халамжын тэтгэлэг авдаг бол тухайн нийгмийн халамжын газрын тодорхойлолтыг мөн өргөдөлдөө хавсаргана. **Гомдол болон үүнд хамаарах нотолгоо, баримт материалуудыг бүгдийг хоёр дахин хувилна.**

14 Гурван хувь гомдол тус бүр дээр гарын үсэг зурна. Үүнээс **хоёр хувь гомдлыг** бүх материалуудын (Цагаачлалын албанаас (BFM) авсан шийдвэр, нийгмийн халамжын газрын тодорхойлолт болон өөрийн бусад нотолгоо баримтууд) хамт баталгаажуулсан захидлаар энэ хаяг руу **явуулна**: Bundesverwaltungsgericht, Postfach, 3000 Bern 14 **Заагдсан хугацааг анхаар!**

5. Цаашид юу болох вэ?

Та Улсын засаг захиргааны шүүхээс (Bundesverwaltungsgericht) бичгээр хариу авна. Захидлыг хүнээр орчуулуулж унших хэрэгтэй, зарим тохиолдолд захидлын дагуу харьцах шаардлага гарч болно. Улсын засаг захиргааны шүүхийн шийдвэр олон янз байна. Энд чухал хэлбэрүүдээс хэдэн жишээ дурьдахад:

Улсын засаг захиргааны шүүхээс таны гомдол, материалыг **хүлээн авсныг баталсан захидал** байж болно. Энэ тохиолдолд та шүүхийн шийдвэр гартал хууль ёсоор Швейцар улсад үлдэж болно. Шүүхийн шийд богино хугацаанд (хэдэн өдрийн дотор) багтаж гарна.

- Улсын засаг захиргааны шүүх таны гомдлыг **«анхнаасаа явуургүй, үндэслэл муутай»** гэж үзсэн шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд таниас гомдлыг шүүхээр авч хэлцэхтэй холбогдсон **зардалыг** төлөхийг шаардаж хугацаа өгсөн байна. Төлбөрийг төлөөгүй тохиолдолд таны гомдол шүүхээр авч хэлцэгдэхгүй. Төлбөрийг заасан хугацаанд төлсөн тохиолдолд таны гомдол шүүхээр авч хэлцэгдэх боловч нааштай хариу гарах магадлал маш бага.
- Улсын засаг захиргааны шүүх таны гомдлын алдааг засаж сайжруулах шийдвэр гаргаад танд хугацаа өгсөн байж болно. Энэ тохиолдолд та нэн даруй юу шаардсаны дагуу хандах хэрэгтэй. Эс тэгвээс таны гомдлыг цаашаа хянаж үзэхийг зогсооно.
- Улсын засаг захиргааны шүүх танд цагаачлалын албанд ахин хандаж шинээр орогнох хүсэлтээ гаргах боломж олгоно. Энэ тохиолдолд даруй цагаачлалын албанд хандах хэрэгтэй
- **Улсын засаг захиргааны шүүхийн тогтоол** янз бүр байж болохын нэг хэлбэр нь сөрөг шийдвэр. Сөрөг шийдвэр гарсан тохиолдолд та Швейцар улсыг орхин гарах ёстой. Шүүхийн шийдвэртэй холбогдсон бүх материал Улсын засаг захиргааны шүүхээс цагаачлалын албанд тодруулахаар шилжүүлэгдэнэ. Эерэг шийдвэр гарсан тохиолдолд та Швейцар улсын цагаачлалын эрх авах буюу түр хугацаагаар хүлээн авагдана.

Гомдлын дагуу гарсан Улсын засаг захиргааны шүүхийн шийдвэр нь ер нь эцсийн шийдвэр болдог. Цааших шатны шүүхэд даваж заалдах боломжгүй. Маш онцгой тохиолдолд даваж заалдах боломж байж болно. Энэ талаар хуулийн зөвлөлгөө өгөх газарт хандаж мэдээлэл авч болно. (<http://www.fluechtlingshilfe.ch/hilfe/nuetzliche-adressen>)